# Цогтцэций сумын Эрүүл Мэндийн Төв

## ТҮҮХЭН ЗАМНАЛ
## ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ
## ОЛОЛТ АМЖИЛТ
## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

# Түүхэн замнал

- Анх 1929 онд тус сумын Сэвхүүл гэдэг газар хүн эмнэлгийн тасаг анх байгуулагдсан. Эмчээр нь Оросын бага эмч Маквев ажиллаж байв. 1938 онд одоогийн сумын төвд нүүн ирж, Долгорын Жимэнхүү гэдэг бага эмч ажиллаж байсан. 1940 онд тус суманд эмнэлгийн шинэ барилга ашиглалтанд орж, бага эмчийн салбар орон тоо, зохион байгуулалтын хувьд өргөжин их эмчийн салбар байгуулахад нөлөөлсөн. 1948 онд их эмчийн салбартай болж, Их усны зүүн хойно /Баруун суугийн ус/ байрлаж эрхлэгч эмчээр нь Ж.Равсал, бага эмчээр Н.Балдандорж, эмийн санчаар С.Лувсанцэдэн нар ажиллаж байсан. 1961 онд хүн эмнэлгийн салбар 13 орон тоотой, эмч, сувилагч /Их эмч Гончиг/ нар сэхээтний нөхөрлөл байгуулан ажилласан.

- Үүнээс хойш их эмчийн салбарын эрхлэгчээр Төмөрпүрэв, Рэнцэндорж, Жаалхүү, Ч.Буянжаргал, Пагма, Э.Ганцэцэг, Рэнцэнноров, М.Цэндсүрэн, Цэцэг-Өлзий, М.Оролмаа, Б.Номинчулуун, Д.Дэлгэрмаа, Б.Сэлэнгэ, Ц.Баяржаргал, Б.Амартүвшин нар тус тус ажиллаж байна.
- Тус суманд 1994 онд засгийн газраас П.Жасрай ирж, сум орны ажил төрөл “Таван толгой” нүүрсний орд болон малчид ард иргэдийн амьдралтай танилцаж, эмнэлгийн барилгын хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж, сумын “Эрүүл мэндийн төв” гэсэн нэртэйгээр 1995 онд 15 ортой шинэ эмнэлэг ашиглалтанд орсон.
- Эрхлэгч эмчээр нь Д.Дэлгэрмаа /1993 онд Хүүхдийн эмч мэргэжлээр төгссөн/ ажиллаж 15 орон тоотойгоор /их эмч-1, багийн бага эмч 3, эх баригч 1, дүн бүртгэгч 1, сувилагч 4, асрагч 1, тогооч 1, нярав 1, жолооч 1, угаагч 1, /сумын 1500-1800 иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж ирсэн/

# Сумын эрүүл мэндийн төв /1996-2016он/



# Цогтцэций Сум Дундын Эмнэлэг /50 ортой/ 2016 он




P

# Хөгжил, дэвшил

- 2008 оноос эхлэн уул уурхай хөгжиж эхлэн, хүн амын төвлөрөл ихсэхийн хэрээр эрүүл мэндийн боловсон хүчин, тоног төхөөрөмж, хүн хүч, барилга байшин, эмч мэргэжилтнүүдийг төрөлжсөн болон нарийн мэргэжил эзэмшүүлж, мэргэшүүлэх нь нэн шаардлагатай тулгамдсан асуудлын нэг болсон.
- Эрхлэгч эмч Д.Дэлгэрмаа нь орон тоог нэмэгдүүлэн 20-40 ажилтантай, нийт мэргэжилтнүүдийн 86-90% нь нарийн мэргэжил болон төрөлжсөн мэргэжил эзэмшиж, оношлогоо шинжилгээний тоог нэмэгдүүлэн, багаж тоног төхөөрөмжийн ашиглалт, оношлогоог олшруулсан.
- 2016 онд улсын төсвөөр 5.2 тэрбумын өртөгтэй 50 ортой эмнэлэг ашиглалтанд орж, 2019 онд “Сум дундын эмнэлэг” болж өргөжсөн.

# Хүний нөөц 2024 он

- Анагаах ухааны магистр – 3
- Ахлах зэрэгтэй мэргэжилтэн – 3
- Нарийн мэргэжлийн эмч – 10
- Нийт эмнэлгийн ажилчид - 55




# Бусад ажиллагсад -20

| Албан тушаалын нэр | Тоо |
|---|---|
| | |
| НЭМ | 1 |
| Нярав | 1 |
| Жолооч | 3 |
| Угаагч | 1 |
| Үйлчлэгч | 6 |
| Тогооч | 2 |
| Галч | 4 |
| Цахилгаанчин | 1 |
| Нягтлан бодогч | 1 |

# Сувилагч тусгай дунд мэргэжилтэн -20

**Баклавр сувилагч - 6**

- Нярайн 1
- Өрхийн сувилагч 1
- Мэдээгүйжүүлэг 1
- Ерөнхий мэргэжлийн 3

**Дипломын сувилагч - 4**

- Дархлаажуулалт 1
- Ерөнхий мэргэжлийн 2
- Нүүр амны сувилагч-1



# Сүүлийн 5 жилийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний статистик үзүүлэлтийг хүснэгт, графикаар харуулвал





ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭГЧДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ
6.8
6.6
6.4
6.2
6
5.8
5.6
5.4
5.2
1600
1400
1200
1000
800
600
400
200
0
1268
1173
1451
1165
1208
5.9
5.8
6.7
6.5
6.2
2019
2020
2021
2022
2023
хэвтэн эмчлүүлэгчид
дундаж ор хоног

| Д/Д | Үзүүлэлтүүд | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үйлчлэх хүрээний хүн амын тоо /бүртгэлтэй/ | 8111 | 8439 | 8632 | 8926 | 9860 |
| 2 | Өрхийн тоо | 2597 | 2600 | 2658 | 2813 | 3247 |
| 3 | 0-5 нас хүртэлх хүүхдийн тоо | 1171 | 1167 | 1150 | 1363 | 1633 |
| 4 | Төрөх насны эмэгтэйчүүдийн тоо | 2128 | 2190 | 2218 | 2819 | 2551 |
| 5 | Түргэн тусламжийн дуудлага | 803 | 710 | 786 | 878 | 1214 |
| 6 | Бүртгэгдсэн осол гэмтлийн өвчлөл | 184 | 165 | 122 | 263 | 403 |
| 7 | Нийт төрөлт | 215 | 213 | 213 | 149 | 298 |
| 8 | Бүртгэгдсэн өвчлөл | 6166 | 5600 | 5033 | 10508 | 9328 |
| 9 | Хүлээн авах яаралтай тусламжаар үйлчлүүлэгчдийн тоо | 499 | 530 | 534 | 765 | 2139 |

# Үе үеийн ахмад эмч, эмнэлгийн ажилчид





Анх удаа суманд “Энэрэхүй-Ухаан” ӨЭМТ байгуулагдаж, 9 хүний орон тоотой, даргаар нь Б.Үүрийнцолмон, С.Сарантуяа, Б.Бадамхатан, Э.Оюунтунгалаг нар  ажиллаж, иргэдэд тусламж үйлчилгээг үзүүлж байсан. /2015-2021 он/






# Сумын ЭМТ-ийн танилцуулга

- Одоо тус эмнэлэг нь  Б.Амартүвшин даргатай сумын эрүүл мэндийн төв /А зэрэглэл/ гэсэн статустай, 66 орон тоотой батлагдаж, 7 тасагтай,  55 ажилтантай үүнээс их эмч-14, сувилагч-10, тусгай мэргэжилтэн-10, эмнэлгийн ажилчид-13, гэрээт ажилчин-4, нийт мэргэжилтнүүдийн 90% нь мэргэшсэн болон төрөлжсөн мэргэжил эзэмшсэн эмч, сувилагч нар ажиллаж байна. Жилдээ 20000-23000 иргэнд амбулаторын үзлэг, шинжилгээ оношлогоог хийж, 1200 иргэнийг хэвтэн эмчлүүлж, 70-80 хүнд мэс заслын тусламж, 1200-1300 иргэдэд түргэн тусламжийн дуудлага,120-130 хүнд төрөхийн тусламж, 2300-2500 иргэдэд хүлээн авах яаралтай тусламжийн тусламж үйлчилгээг тус тус  хөнгөн шуурхай хүргэж байна.

# Сумын ЭМТ – ийн хамт олон 2024 он



# Цогтцэций сумын эрүүл мэндийн төв

- Сүүлийн 3 жилийн ололт амжилт, хөрөнгө оруулалт
- Орон нутгийн хөрөнгө оруулалт ЗДТГ – ИТХ
- Улсын төсөв
- Өмнөговь аймгийн ЗДТГ - ИТХ

# Цогтцэций сумын эрүүл мэндийн төв

- Орон нутгийн хөрөнгө оруулалт Цогтцэций сумын Засаг Даргын Тамгын газар Иргэдийн төлөөлөгчийн хурал

# 5D-Хэт авиан аппарат 170 сая.төг Цусны ерөнхий шинжилгээний аппарат 30 сая.төг






# 220 Вт Цахилгаан генератор 70 сая.төг





# “Эрүүл-Эерэг-Энх-Тунх иргэн” хөтөлбөр 100 сая.төг /Сумын ИТХ, 2022-2024 он/

- 2022  он 100% хэрэгжсэн
- 2023 он 100% хэрэгжсэн
- 2024 он 45% хэрэгжиж байна.
- Нийт төсөв 300 сая.төг

# Бохирын шугамын холболтын ажил 150 сая.төг







# Эмгэг судлалын кабинет /Моорог/ засвар 50 сая.төг





# Дотор хаалга





# Дотор засвар







# Сумын эрүүл төвийн В1 Давхарын засвар 284 сая.төг

- В1 давхарын дотор засварын ажил 70%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.

# Улсын төсөв

# Улсын төсөв 177 сая.төг 2023 он
/УИХ-ын гишүүн Д.Бат-Эрдэнэ/






# Орон нутгийн хөрөнгө оруулалт

- Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар
- Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчидийн Хурал
- Нийгмийн Бодлогын Хэлтэс

# Эрүүл мэндийн төвийн цахилгаан шат 150 сая.төг 2023 – 2024 он /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Г.Цог-Өрнөх/



# Молекуль биологийн лабораторийн засвар өргөтгөл

/280 сая төгрөгний өртөг Логмон ххк 2022 онд гүйцэдгэсэн/





# Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлгийн аппарат, 2023 он /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч Г.Цог-Өрнөх/



# Гал тогооны 25 төрлийн иж бүрэн тоног төхөөрөмж 50 сая.төг, 2023 он










ат 20

Ц.Дэнээ



# Зөөврийн рентген аппарат 114 сая.төг, 2022 он АЗДТГ Нийгмийн бодлогын хэлтэс





# B1 давхарын цутгалт 290 сая.төг

- ‘’Бүтэн тред‘’ ХХК  цутгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн, 2022 он

# Уул уурхайн компаний хөрөнгө оруулалт

# ‘’Эрдэнэс Тавантолгой’’-ХК Нэг-Тэрбум төгрөг



БАТЛАМЖ

"Эрдэнэс Тавантолгой" ХК хариуцлагатай уул уурхай нийгмийн хариуцлагын хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын эмнэлэгт НЭГ ТЭРБУМ төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийг олгохыг батламжилж байна.

2023.05.27





# Эрдэнэс Тавантолгой-ХК





# “ЭТТ”-ХК, ХАЯТТ- 20 сая.төг 2023 он







# Молекуль биологийн лабораторын тоног төхөөрөмж 207 сая.төг

/Эрдэнэс таван толгой 120 сая.төг, НҮБ-хүн амын сангаас 150 сая.төг/





# “Энержи-ресурс” ХХК, угаасан нүүрс-250 тн





# Сумын эрүүл мэндийн төвийн ололт амжилт

# Мэс заслын тасгийн нээлт, 2016 он

- Анх удаа хөдөө орон нутагт мэс заслын тасаг нээгдэж, анхны мэс заслын тусламж үйлчилгээг төрөлжсөн нарийн мэргэжил эзэшсэн эмч Б.Амартүвшин мэс заслын баг бүрэлдэхүүн нь амжилттай хийж, жилдээ 70-80 иргэдэд цаг алдалгүй тусламж үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлж ирсэн байна.
- Мэс засал, төрөх эмэгтэйчүүдийн тасгийг 2016 онд ‘’Энержи-ресурс’’ ХХК 390 сая төгрөгний санхүүжилтээр тохижилт болон тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж өгсөн.

# Мэс заслын тасгийн нээлт 2016 он





# Одоог хүртэл мэс заслын тусламж үйлчилгээ тасралтгүй хэвийн үргэлжилж байна. / Мэс заслын хэсэг – 2016-2024 он/





# Хагалгааны хэсгийн үйл явц





# Хагалгааны хэсгийн үйл явц





# Өмнөговь аймгийн элэгний хавдрын эрт илрүүлэг 1-р байр, 2023 он



# “Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд “Сүү - тараг” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж тэргүүн байр эзэлсэн, 2023 он



# “Эрүүл монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд БОЭТ-тэй гэрээ байгуулж,18-30 насны эрт илрүүлгийн үзлэгийг сумын иргэд болон тойргийн сумдын иргэдэд амжилттай хийж байна, 2023 он





# Эрүүл мэндийн байгууллагуудын зүүн бүсийн спортын 5 төрөлт наадмын 3 удаагийн аварга хамт олон







*Анхаарал хандуулсанд баярлалаа*